



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/278

Сүхбаатар сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3 заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Аймаг хөгжүүлэх сан"-аас олгосон зээлийн эргэн төлөлтийг эрчимжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Ж.Сайнцог

-Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд:

Д.Ёндонжамц

-Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Б.Мөнхзул

-Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга

Б.Мөнхтөр

-Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

П.Ганболд

-Хүнс, хөдөө аж ахуйн газрын Жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн

З.Загдсүрэн


-Нийтлэг үйлчилгээний албаны Тооцооны нягтлан бодогч

М.Тэмүүлэн

-“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын дарга

2. "Аймаг хөгжүүлэх сан"-аас зээлдэгчийн эргэн төлөлтийг зээлдэгч нэг бүртэй тохирох, хугацаатай гэрээ байгуулах, хэрэгжүүлээгүй нөхцөлд шүүхээр дамжуулан шийдвэрлэх арга хэмжээ авч үр дүн, холбогдох дүгнэлт, саналыг нэгтгэн аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд тогтмол танилцуулахыг ажлыг хэсгийн ахлагч /Ж.Сайнцог/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ